



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫ  
БҮРТГЭЛИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ**

14171 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Цагдаагийн гудамж, Утас: 351245.

Факс: (976-11) 351245

<http://www.burtgel.gov.mn>

Х.Н. А.А. № 6630

Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг  
хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1 дэх заалт, Ул бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалын хавсралт баталсан "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам"-ыг дахь хэсэгт заасныг ҮНДЭСЛЭХ нь:

Ардчилсан намын дарга С.Эрдэнээс 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдр 01/325-3 дугаар албан бичгээр "... С.Эрдэнэ миний бие нь 2017 оны 03 дугаар сар 15-ны өдрийн Улсын Дээд Шүүхийн 01 тогтоолоор Ардчилсан намын хууль ёсны бүхий даргаар томилогдсон. Улсын Дээд Шүүх С.Эрдэнийг Ардчилсан намын дарга томилсныг 8488916 тоот регистрийн дугаар бүхий улсын бүртгэлийн гэрчилгээ бүртгэлд хуульд нийцүүлэн бүртгэж тэмдэглэсэн. Ц.Туваан Ардчилсан нам 1117237845 дугаар бүхий тамгыг эргүүлэн өгөх шаардлагыг биелүүлэхгүй удаа дах Ардчилсан Үндсэн дүрэм болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа тул Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1 дах хэсгийг баримтлан өргөдөл гаргаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуули 12.1, 12.2.3, 19.4.7 дах хэсгийг баримтлан С.Эрдэнийг Ардчилсан намын дарга бүртгэсэн бүртгэл өнөөдрийг хүртэлх хугацаанд хүчинтэй хэвээр байгаа т Ц.Тувааны ашиглаж буй Ардчилсан намын 1117237845 дугаар бүхий тамгыг хүчинг болгож, Ардчилсан намын тамгыг шинээр хийлгэх зөвшөөрөл олгож өгнө үү" г хүсэлтийн дагуу холбогдох бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд тамга, тэмдгий хяналтын 1117237845 дугаарыг Ардчилсан намд 2017 оны 3 дугаар сарын 03-ны өдө олгосон бүртгэлтэй байх бөгөөд Улсын дээд шүүхээс 2006 оны 7 дугаар сарын 10-н өдөр олгосон улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлийн дугаар 803200100; регистрийн дугаар 8488916, Содномзундуй овогтой Эрдэнийг 2017 оын 3 дугаа сарын 15-ны өдөр Н.Мөнхтулга бүртгэсэн бичилттэй байна.

2.С.Эрдэнийн хүсэлтэд Ардчилсан намын Үндсэн дүрмийн хорооны 2020 оны дугаар сарын 03-ны өдрийн 16 дугаар тогтоолыг хавсаргаж ирүүлсэн, уг тогтоол; Ардчилсан намын дарга нь Үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.101.4-р заалтын дагу; сонгогдож, 5 дугаар бүлгийн 5.12.4.8-д заасны дагуу батламжлагдах шинэ дарга эр; үүргээ шилжүүлнэ гэж заасан байх ба тогтоолд нэр бүхий 11 гишүүн гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр 02/10759 дүгээр албан бичгээр иргэн Ц.Туваанд Ардчилсан намын дарга С.Эрдэнэ ирүүлсэн хүсэлттэй танилцаж, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 2-д дахь заалтад заасны дагуу тайлбар, саналаа 2020 оны 12 дугаар сарын 24 өдрийн дотор ирүүлэх талаар мэдэгдсэн.

Уг мэдэгдлийн дагуу Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга П.Пүрэглэгийн гарын үсэг бүхий 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 02/453 дугаар албан бичиг, Монгол Улсын Их Хурлын гишүүн, намын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваанд тайлбар, Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны хурлын 2020 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 дугаартай Ардчилсан намын даргын эрх, үүргийг нэг дараагийн дарга сонгогдох хүртэл Цэвэгдоржийн Туваанд түр шилжүүлсэн тул тогтоолыг тус тус ирүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5/5051 дугаар албан бичиг байх ба уг албан бичигт Ардчилсан намаас 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 02/418 тоот дугаартай "Бүртгэж өөрчлөлт оруулах тухай" албан бичиг ирүүлснийг үндэслэн Улс төрийн нам бүртгэлийн програмд Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Туваанд бүртгэсэн байна гэсэн байна.

4. С.Эрдэнээс тус газарт 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн тайлбарт "2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Ардчилсан намын 7 дугаар сарын хурлын 03 дугаар тогтоолоор Ардчилсан намын даргаар С.Эрдэнэ сонгогдсон Монгол Улсын Дээд Шүүх 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор бүртгэн баталгаажуулсан. Мөн үүнийг улсын бүртгэлийн 8488916 тоот регистрийн дугаар бүхий гэрчилгээн дээр 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдөр С.Эрдэнэ Ардчилсан намын даргаар томилсныг бүртгэсэн бөгөөд эдгээр шийдвэртэй холбоотой үүссэн аливаа маргаан, асуудал өнөөдрийг хүртэл гараагүй болно. Ардчилсан намын дүрмийн 5.12.4.8-д Ардчилсан намын даргыг ёсчлон батламжлах гэж заасан бөгөөд намын даргын үүрэг гүйцэтгэгч гэж албан тушаалд хэн нэгийг баталдаг зүйл заалт байхгүй. Өнөөдөр Улсын Дээд Шүүхийн Тамгын газраас Ардчилсан намын Үндэсний дүрэмд заагаагүй албан тушаал буюу Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгч гэж албан тушаал дээр хэн нэгэн этгээдийг Улсын Дээд Шүүх тогтоол, шийдвэргүйгээр томилж буюу бүртгэх эрхгүй юм..." гэжээ.

Дээрх баримт, тайлбартай холбоотойгоор Ардчилсан намын тамгыг өгөхгүй байгаа асуудал нь тус газрын чиг үүрэгт хамаарахгүй байх тул холбогдох хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

С.Эрдэнэний хүсэлт, Ардчилсан намын улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн бүртгэлийг үндэслэн тус намын тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох нь зүйтэй.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4.1.4 дэх заалтад "үнэн зөв, бодитой заавал биелүүлэх шинжтэй байх" гэж заасныг тус баримтлан ДҮГНЭХ нь:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь тамга, тэмдгийн хяналтын дугаарын санд Ардчилсан намын тамга, тэмдгийн хяналтын 1117237845 дугаарыг хүчингүй болгох.

ХЯНАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ

A handwritten signature in black ink, consisting of stylized Cyrillic letters, likely 'Д.Чинтулга'.

Д.ЧИНТУЛГА

УБ -14 маягт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2018 оны А/420 дугаар тушаалын 12 дугаар  
хавсралт

**ТАМГА, ТЭМДГИЙН ХЯНАЛТЫН ДУГААРЫН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

2020 он 12 сар 25 өдөр

1.Хуулийн этгээдийн нэр, хэлбэр: **Ардчилсан нам,  
Улс төрийн нам**

2.Хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар:

3.Хуулийн этгээдийн регистрийн дугаар: 8488916

4.Тамга, тэмдгийн хяналтын дугаар 9020120477

5.Хяналтын дугаар олгох үндэслэл:


Шинэ

Дахин /гэмтээсэн, оноосон нэр өөрчилсөн, тамга,  
тэмдгийн хуудас үрэгдүүлсэн, устсан, хүчингүй болгосон,  
шилжилт хөдөлгөөн хийсэн, үрэгдүүлсэн, өөрчлөн  
байгуулагдсан/

/өргөдөл гаргагч аль тохирох нэгдэнд  
✓ тэмдэглэгээ хийнэ./

/доогуур зурж тэмдэглэнэ/

УЛСЫН БҮРТГЭГЧ:  
/Тэмдэг/



*[Signature]*  
/Гарын үсэг/

/Э.Баточир/  
/Гарын үсгийн тайлал/

Үйлдвэрээс улсын бүртгэлийн байгууллагад буцаах /тайлагнах/ хэсэг


1.Хуулийн этгээдийн нэр, хэлбэр: **Ардчилсан нам,  
Улс төрийн нам**

2.Хуулийн этгээдийн регистрийн дугаар: 8488916

3.Тамга, тэмдэг үйлдвэрлэсэн хуулийн этгээдийн нэр:

4. Тамга, тэмдэг үйлдвэрлэсэн он, сар,  
өдөр: 2020.12.25

Үйлдвэрлэгчийн гарын үсэг:



Тамга, тэмдгийн дардас

2020.02.02

2020.12.25  
Нийслэл Сүхбаатар дүүрэг  
голборлогч газартай 13 хандалтын гудамж  
Энэ хуудсаар хуудас үрэгдүүлсэн, устсан, хүчингүй болгосон,  
шилжилт хөдөлгөөн хийсэн, үрэгдүүлсэн, өөрчлөн байгуулагдсан  
Үйлдвэрлэгчийн гарын үсэг: *[Signature]*  
Нотариус: *[Signature]*